



Бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах журмын Нэгдүгээр хавсралт

ЗАХИАЛГЫН ХУУДАС

Огноо: 2021.02.22

Дугаар: 167-01-01-2.3.3.1.1

Байгаль орчин, усны бодлогын хэлтэс

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Зориулалт	Техникийн тодорхойлолт	Үлдэгдэл /Тоо ширхэг/
1	Усны чанарыг хэмжих төхөөрөмжийн нэмэлт хэрэгсэл	багц	1	Байгаль орчны хэрэгцээнд YSI үйлдвэрийн Profes- sional Plus усны чанарын багаж ашиглаж байгаа ба тус багажны калибраци хийхэд шаардлагатай.	Хавсралтаар	



Бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах журмын Нэгдүгээр хавсралт

Хавсралт 1

УСНЫ ЧАНАРЫГ ХЭМЖИХ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭМЭЛТ ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ҮНДЭСЛЭЛ

Байгаль хамгаалах тухай хуулиар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа эрхлэгч нь байгаль орчны хяналтыг явуулж байх ёстой. Компаний зүгээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хуваарийн дагуу усны хяналт шинжилгээг явуулдаг ба 2017 оноос байгаль орчны хэрэгцээнд ашиглахаар YSI үйлдвэрийн Professional Plus усны чанарын шууд хэмжилтийн өндөр нарийвчлалтай багаж худалдан авч үйл ажиллагаанд ашиглаж байна.

Уул уурхайн гадаргын усанд үзүүлэх нөлөөллийг үндэслэлтэйгээр тодорхойлох зорилгоор компанийн зүгээс сар бүр тогтмол хянадаг ба энэхүү багажийг дагалдах хэрэгсэлийг хамт уурхайн ойр орчмын малчдын гар худгуудын усны чанарыг хянахад ашиглагдана.

Тус багаж нь усны температур, цахилгаан дамжуулах чанар хэмжих кабельтай ба буусд номолт хэрэгсэл ашиглан усны урвалын орчин pH, ууссан хүчилтөрөгч /DO/, цэвэр усны хлорид, аммони, нитрат хэмждэг ба үйлдвэрт хүргүүлэхгүйгээр хэрэглэгч өөрөө калибраци тохиргоо хийж болдог онцлог давуу талтай.

Энэ оны худалдан авалтаар тус багажны калибраци хийхэд шаардлагатай стандарт уусмалууд, ангижруулагч проб, малчдын худгаар авч явж ашиглахад шаардлагатай хамгаалалтын цүнх, лабораторид шинжилгээ хийхэд шаардлагатай багажны суурь зэргийг захиалан авч хэмжилтийн үнэн зөв байдлыг хангах, багажийг аюулгүй ашиглах, эдэлгээг уртасгах шаардлагатай.

УСНЫ ЧАНАРЫГ ХЭМЖИХ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭМЭЛТ ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Нийлүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага

- YSI үйлдвэрийн брэндийн төхөөрөмжийг МУ-д импортолж нийлүүлэх чадвартай.
- YSI үйлдвэрийн сери дугаарын дагуу нийлүүлнэ.
- Тус багц иж бүрдлийг худалдан авч захиалгач талд нийлүүлэхэд гарах бүх зардлыг нийлүүлэгч тал хариуцна.
- Бараа нь шинэ, үйлдвэрийн баглаа боодол дагалдах бусад хэрэгсэл, баримттай байна
- Уусмалуудын лац алдагдаагүй, бүрэн бүтэн асгараагүй байх.
- Барааг YSI ProPlus төхөөрөмжинд холбож ажиллаж байгаа эсэхийг шалгаж авна

2. Нэмэлт мэдээлэл

- Бараа бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах цахим хуудас: <https://www.ysi.com/>
- Тус багаж нь YSI үйлдвэрийн багаж тул тус үйлдвэрийн стандарт уусмалуудыг ашиглан калибраци хийх боломжтой тул өөр үйлдвэрийнх уусмалууд байх боломжгүй.
- Барааг угсарсан улс: АНУ, Их британи, Канад

№	Бүтээгдэхүүний нэр	Тоо ширхэг	Шаардлага	Зураг
1	Стандарт уусмал (Нитрат)	1 ш	500 мл, концентраци 1мг/л SKU: 003885	
2	Стандарт уусмал (Нитрат)	1 ш	500 мл, концентраци 10 мл/л. SKU: 003886	
3	Стандарт уусмал (Нитрат)	1 ш	500 мл, концентраци 100 мл/л. SKU: 003887	
4	Стандарт уусмал (Аммони)	1 ш	500 мл, концентраци 1 мл/л. SKU: 003841	
5	Стандарт уусмал (Аммони)	1 ш	500 мл, концентраци 10 мл/л. SKU: 003842	
6	Стандарт уусмал (Нитрат)	1 ш	500 мл, концентраци 100 мл/л. SKU: 003843	
7	Стандарт уусмал (pH)	1 ш	475 мл, pH 4.00 SKU: 003821	
8	Стандарт уусмал (pH)	1 ш	475 мл, pH 7.00 SKU: 003822	
9	Стандарт уусмал (pH)	1 ш	475 мл, pH 10.00 SKU: 003823	



Бараа, ажил, үйлчилгээ худалдан
авах журмын Нэгдүгээр хавсралт

10	Ангижруулагч проб	1 ш	Pro Plus төхөөрөмжийн зориулалтын сэлбэг. Барааны дугаар SKU: 605324	
11	Стандарт уусмал (ORP)	1ш	500 мл, концентраци 10 мл/л. SKU: 061322	
12	Багаж хамгаалах тавиур	1ш	Мэдээлэл боловсруулах явцад ашиглах багажны суурь SKU: 626444	
13	Багажны хамгаалалтын цүнх	1ш	Багаж аюулгүй зөөвөрлөх хамгаалалтын цүнх SKU: 603075	